

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	19
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27
7. АКТ, АЛБАН ШААРДЛАГУУД	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татварын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/302

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,226,415.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.4, 16 дугаар зүйлийн 16.5, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тус яам 1,096,397.5 мянган төгрөгийн зээлийн хүүгийн дэмжлэгийн өр төлбөр үүсгэж, харилцагчидтай тооцоо нийлээгүй, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт бүртгэлээр хяналт тавиагүй, Санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан эрх үүргийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй;
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 59,384.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд үүнээс төлөвлөх боломжтой тогтмол түрээсийн орлогыг төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй;
- Төсвийн захирагч төсвийг зохистой удирдаагүйгээс 40,539.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 55, 2025 оны 241 дүгээр “Хөрөнгө гаргах тухай” тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас үерийн улмаас эвдэрсэн улсын чанартай авто зам, замын байгууламжийг засах, Ханбогд-Манлай-Өлзийт-Мандалговь чиглэлийн авто замын техник, эдийн засгийн үндэслэл зураг төсөл боловсруулахад нийт 18 гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан 2,664,220.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 521 дүгээр “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 387,840.0 мянган төгрөгийн үнэ бүхий 164 хөрөнгийг данснаас хасаж, мөн оны 621 дүгээр “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолоор 596,542.0 мянган төгрөгийн өртөг бүхий 5 автомашиныг харьяа газрууд руу шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Зам, тээврийн салбарт нийт 80 олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулж, үүнээс авто тээврийн салбарт 20, иргэний нисэхийн салбарт 49, төмөр замын салбарт 11 хэлэлцээр байна. Ингэснээр улс хоорондын агаарын тээврийн үйл ажиллагааг эрх зүйн хувьд зохицуулж, аюулгүй, тогтвортой, харилцан ашигтайгаар хөгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ олон улсын түншлэл, харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, зорчигч болон ачаа тээврийн урсгалыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	544,398.21	0.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	544,398.21	0.00
31211	Төрийн сангийн харилцах	544,398.21	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	0.00
33	АВЛАГА	5,229,439,649.93	3,671,436,900.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	4,810,711.74
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	19,630,491.93	1,066,377.31
33500	Бусад авлага	5,209,809,158.00	3,665,559,811.21
33510	Байгууллагаас авах авлага	5,209,809,158.00	3,665,559,811.21
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0.00	1,087,916.77
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	1,087,916.77
35	БАРАА МАТЕРИАЛ	120,318,587.75	97,421,778.24
35400	Хангамжийн материал	120,318,587.75	97,421,778.24
35410	Бичиг хэргийн материал	7,798,530.00	4,043,081.27
35420	Аж ахуйн материал	18,217,793.00	22,680,071.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,042,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	2,381,291.52	1,208.74
35470	Бусад хангамжийн материал	82,878,973.23	70,697,417.23
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,350,302,635.89	3,769,946,595.27
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,500,712,770.84	5,155,129,808.91
39200	Биет хөрөнгө	3,488,111,970.84	3,145,129,008.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,874,853,510.76	2,968,853,510.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-615,762,141.89	-731,325,907.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	484,100,000.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-346,691,443.83	0.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,767,299,756.23	1,340,472,381.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-820,870,016.22	-620,432,042.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	265,242,114.39	241,705,287.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-120,059,808.60	-101,444,463.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	84,089,320.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-36,789,077.66
39300	Биет бус хөрөнгө	2,012,600,800.00	2,010,000,800.32
39301	Программ хангамж	49,427,000.00	49,427,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-39,027,000.00	-41,626,999.68
39303	Бусад биет бус хөрөнгө	2,002,200,800.00	2,002,200,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,500,712,770.84	5,155,129,808.91
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,851,015,406.73	8,925,076,404.18
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,559,190.03	1,138,741,315.79
41300	Өглөг	1,559,190.03	1,133,936,465.79
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,559,190.03	21,477,988.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	1,112,458,477.79
41360	Бусад өглөг	0.00	4,804,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	4,804,850.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,559,190.03	1,138,741,315.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,559,190.03	1,138,741,315.79
51	Засгийн газрын хувь оролцоо	7,873,278,140.11	7,873,278,140.11
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,873,278,140.11	7,873,278,140.11
51101	Өмч: - төрийн	7,873,278,140.11	7,873,278,140.11

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51200	Хуримтлагдсан үр дүн	2,730,437,551.34	-332,683,576.97
51210	Өмнөх үеийн үр дүн	3,268,846,773.98	2,705,718,828.87
51220	Тайлант үеийн үр дүн	-538,409,222.64	-3,038,402,405.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245,740,525.25	245,740,525.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	10,849,456,216.70	7,786,335,088.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	<u>10,851,015,406.73</u>	<u>8,925,076,404.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,501,434,226.00	13,686,994,398.00
1310	Улсын төсвөөс	13,430,703,105.00	10,884,524,655.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,430,703,105.00	10,884,524,655.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,070,731,121.00	2,802,469,743.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,070,731,121.00	2,660,845,076.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	0.0	90,640,207.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	50,984,460.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	110,940,349.40	209,013,181.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,540,349.40	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	103,540,349.40	0.00
120009	Бусад орлого	7,400,000.00	228,894.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	208,640,094.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	144,193.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,612,374,575.40	13,896,007,579.50
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	6,561,562,809.01	6,515,000,802.96
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,837,293,777.25	5,777,730,627.39
210101	Үндсэн цалин	3,438,707,963.32	3,312,948,097.74
210102	Нэмэгдэл	1,066,863,807.75	1,017,484,369.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	975,964,500.00	1,001,960,660.00
210104	Урамшуулал	355,757,506.18	445,337,500.00
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	724,269,031.76	737,270,175.57
210201	Тэтгэврийн даатгал	494,609,051.57	512,925,324.84
210202	Тэтгэмжийн даатгал	60,136,922.39	57,543,303.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,212,338.84	29,751,136.65
210204	Ажилгүйдлийн даатгал	27,910,568.07	27,284,209.30
210205	Эрүүл мэндийн даатгал	112,400,150.89	109,766,201.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	6,432,597,374.64	4,472,184,978.92
2104	Хангамж, бараа материалын зардал	241,230,828.42	154,458,506.79
210401	Бичиг хэрэг	47,576,541.00	38,208,235.73
210402	Тээвэр, шатахуун	12,031,640.88	8,692,166.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,975,185.56	37,696,689.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	134,647,460.98	69,861,416.00
2105	Нормативт зардал	7,804,900.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,804,900.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	352,242,147.00	90,312,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	607,299.00	180,000.00
210602	Тавилга	726,500.00	60,000.00

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	350,908,348.00	90,072,700.00
2107	Томилолт, зочны зардал	681,483,108.00	246,380,000.00
210701	Гадаад албан томилолт	287,261,391.00	148,488,240.18
210702	Дотоод албан томилолт	394,221,717.00	97,891,759.82
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,591,205,158.89	659,654,039.93
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр хураамж	1,499,141,180.00	572,255,190.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	608,148.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	778,532.00	1,067,648.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	83,000.00	22,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	71,047,796.89	73,492,277.93
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,818,576.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,154,650.00	4,390,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,558,631,232.33	3,321,379,732.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,097,927,181.02	2,676,677,372.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	42,750,000.00	85,991,913.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	417,954,051.31	558,710,447.20
212	ТАТААС	3,284,421,292.03	3,519,230,407.79
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,284,421,292.03	3,519,230,407.79
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,284,421,292.03	3,519,230,407.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	819,690,964.03	2,325,907,498.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,839,154.56	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	28,839,154.56	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	450,142,912.72	414,401,260.38
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,850,000.00	22,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	240,550,000.00	286,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	170,742,912.72	105,101,260.38
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	333,908,896.75	1,911,506,238.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	333,908,896.75	1,911,506,238.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,800,000.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,800,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	17,098,272,439.71	16,832,323,688.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-485,897,864.31	-2,936,316,109.11
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	102,086,296.73
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	52,511,358.33	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	52,511,358.33	102,086,296.73
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-538,409,222.64	-3,038,402,405.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,501,434,226.00	18,896,803,556.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,430,703,105.00	10,884,524,655.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,430,703,105.00	10,884,524,655.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,070,731,121.00	8,012,278,901.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,070,731,121.00	2,660,845,076.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	90,640,207.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	5,260,793,618.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	5,657,554,508.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,650,154,508.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,650,154,508.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
120009	Бусад орлого	7,400,000.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	22,158,988,734.00	18,896,803,556.00
	АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	6,580,409,892.49	6,479,729,975.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,848,576,078.92	5,762,806,395.97
210101	Үндсэн цалин	2,935,849,722.21	3,265,875,323.65
210102	Нэмэгдэл	1,604,335,896.46	1,049,413,747.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	956,413,185.59	1,005,982,049.27
210104	Урамшуулал	351,977,274.66	441,535,275.24
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	731,833,813.57	716,923,579.11
210201	Тэтгэврийн даатгал	502,173,833.38	492,231,448.14
210202	Тэтгэмжийн даатгал	60,136,922.39	57,560,666.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,212,338.84	30,143,685.28
210204	Ажилгүйдлийн даатгал	27,910,568.07	27,171,010.68
210205	Эрүүл мэндийн даатгал	112,400,150.89	109,816,768.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	6,079,006,112.45	3,874,966,168.98
2104	Хангамж, бараа материалын зардал	166,855,307.71	120,059,023.05
210401	Бичиг хэрэг	47,466,280.00	24,416,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,413,283.00	7,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,331,186.73	37,696,689.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,644,557.98	50,545,734.00
2105	Нормативт зардал	7,804,900.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,804,900.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	394,909,348.00	91,652,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,791,600.00	180,000.00
210602	Тавилга	1,596,500.00	60,000.00
210604	Урсгал засвар	367,521,248.00	91,412,700.00
2107	Томилолт, зочны зардал	681,401,783.00	246,380,000.00
210701	Гадаад албан томилолт	287,261,391.00	147,619,889.18
210702	Дотоод албан томилолт	394,140,392.00	98,760,110.82
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,687,231,557.72	655,702,869.93

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр хураамж	1,583,437,430.00	556,194,220.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	608,148.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	778,532.00	1,067,648.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	83,000.00	22,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	82,092,195.72	79,968,777.93
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,818,576.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,840,400.00	10,023,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,140,803,216.02	2,761,171,576.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,098,053,216.02	2,675,445,076.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	42,750,000.00	85,726,500.00
212	ТАТААС	3,284,421,292.03	2,422,832,900.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,284,421,292.03	2,422,832,900.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,284,421,292.03	2,422,832,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,029,500,122.03	5,986,967,310.15
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,839,154.56	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	28,839,154.56	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	450,142,912.72	409,901,260.38
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,850,000.00	18,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	240,550,000.00	286,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	170,742,912.72	105,101,260.38
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	333,908,896.75	225,087,826.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	333,908,896.75	225,087,826.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,216,609,158.00	5,351,978,223.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,216,609,158.00	5,351,978,223.21
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	<u>21,973,337,419.00</u>	18,764,496,354.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<u>185,651,315.00</u>	<u>132,307,201.79</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185,651,315.00	132,851,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	185,651,315.00	132,851,600.00
223001	Бусад хөрөнгө	0.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	185,651,315.00	132,851,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	185,651,315.00	132,851,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<u>-185,651,315.00</u>	-132,851,600.00
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	<u>0.00</u>	<u>0.00</u>
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	0.00	-544,398.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	544,398.21	544,398.21
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	544,398.21	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	2,595,026,846.98	10,714,045,512.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			673,819,927.00	673,819,927.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	3,268,846,773.98	11,387,865,439.34
Тайлант үеийн үр дүн			-538,409,222.64	-538,409,222.64
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	2,730,437,551.34	10,849,456,216.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-24,718,722.47	-24,718,722.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	2,705,718,828.87	10,824,737,494.23
Тайлант үеийн үр дүн			-3,038,402,405.84	-3,038,402,405.84
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	-332,683,576.97	7,786,335,088.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,636,064,700.00	10,659,436,828.44	976,627,871.56	91.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,636,064,700.00	10,659,436,828.44	976,627,871.56	91.6
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,636,064,700.00	10,659,436,828.44	976,627,871.56	91.6
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,636,064,700.00	10,659,436,828.44	976,627,871.56	91.6
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	6,634,736,200.00	6,479,729,975.08	155,006,224.92	97.7
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,826,131,300.00	5,762,806,395.97	63,324,904.03	98.9
210101	Үндсэн цалин	3,144,012,700.00	3,265,875,323.65	-121,862,623.65	103.9
210102	Нэмэгдэл	2,111,256,400.00	1,049,413,747.81	1,061,842,652.19	49.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	486,308,900.00	1,005,982,049.27	-519,673,149.27	206.9
210104	Урамшуулал	84,553,300.00	441,535,275.24	-356,981,975.24	522.2
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	808,604,900.00	716,923,579.11	91,681,320.89	88.7
210201	Тэтгэврийн даатгал	570,636,200.00	492,231,448.14	78,404,751.86	86.3
210202	Тэтгэмжийн даатгал	60,417,200.00	57,560,666.88	2,856,533.12	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,667,800.00	30,143,685.28	-3,475,885.28	113.0
210204	Ажилгүйдлийн даатгал	30,166,000.00	27,171,010.68	2,994,989.32	90.1
210205	Эрүүл мэндийн даатгал	120,717,700.00	109,816,768.13	10,900,931.87	91.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	1,413,410,700.00	1,346,972,692.98	66,438,007.02	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	123,626,800.00	120,059,023.05	3,567,776.95	97.1
210401	Бичиг хэрэг	17,897,100.00	24,416,600.00	-6,519,500.00	136.4
210402	Тээвэр, шатахуун	8,600,000.00	7,400,000.00	1,200,000.00	86.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,343,000.00	37,696,689.05	-5,353,689.05	116.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,786,700.00	50,545,734.00	14,240,966.00	78.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	245,689,900.00	206,933,400.00	38,756,500.00	84.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,180,000.00	15,334,600.00	-8,154,600.00	213.6
210602	Тавилга	6,186,100.00	6,186,100.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	232,323,800.00	185,412,700.00	46,911,100.00	79.8
2107	Томилолт, зочны зардал	246,923,500.00	246,380,000.00	543,500.00	99.8
210701	Гадаад албан томилолт	140,360,700.00	147,619,889.18	-7,259,189.18	105.2
210702	Дотоод албан томилолт	106,562,800.00	98,760,110.82	7,802,689.18	92.7
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	696,844,000.00	673,273,769.93	23,570,230.07	96.6
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр хураамж	556,195,200.00	556,194,220.00	980.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,542,400.00	0.00	12,542,400.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,794,600.00	608,148.00	1,186,452.00	33.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,343,800.00	1,067,648.00	276,152.00	79.4

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	448,000.00	22,000.00	426,000.00	4.9
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	101,175,900.00	97,539,677.93	3,636,222.07	96.4
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	8,979,400.00	7,818,576.00	1,160,824.00	87.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,364,700.00	10,023,500.00	4,341,200.00	69.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,326,500.00	100,326,500.00	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,600,000.00	14,600,000.00	0.0	100.0
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	85,726,500.00	85,726,500.00	0.0	100.0
212	ТАТААС	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	694,927,100.00	409,901,260.38	285,025,839.62	59.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,484,500.00	0.00	31,484,500.00	0.0
213102	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,484,500.00	0.00	31,484,500.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	663,442,600.00	409,901,260.38	253,541,339.62	61.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,450,000.00	18,400,000.00	33,050,000.00	35.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	288,604,900.00	286,400,000.00	2,204,900.00	99.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	323,387,700.00	105,101,260.38	218,286,439.62	32.5
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	11,636,064,700.00	10,659,436,828.44	976,627,871.56	91.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	125	119	6	95.2
	Удирдах ажилтан	15	12	3	80.0
	Гүйцэтгэх ажилтан	110	107	3	97.3
	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	125	119	6	95.2
	Төрийн өндөр албан тушаалтан (ТӨ)	2	2	0	100.0
	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	107	101	6	94.4
	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0	100.0
	Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад албан хаагч (ТҮМТ)	2	2	0	100.0
	Төрийн улс төрийн албан тушаалтан (ТУТ)	3	3	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Нэмэлт санхүүжилтийн орлого		8,012,278,901.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,660,845,076.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		90,640,207.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,260,793,618.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		8,012,278,901.00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		
Бараа үйлчилгээний бусад зардал		2,660,845,076.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,660,845,076.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,351,433,825.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,665,015,413.00
Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт санхүүжилт		3,665,015,413.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,686,418,412.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,686,418,412.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		8,012,278,901.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зам тээврийн яам нь зам, тээврийн салбарын хөгжлийн нэгдсэн болон хүний нөөцийн бодлого, автозам, авто тээвэр, төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээвэр, иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, салбар хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг зохицуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, салбарын стандарт, норм, норматив, техник, технологи, судалгаа шинжилгээг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулах, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх.” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт урт 1245.61 км, урсгал засвар, арчлалт хийх авто замын нийт урт 14,921.3 км;
- Товлолт хугацаанд техникийн үзлэгт хамрагдалтыг 100.0 хувьд хүргэх;
- Нийт 1,273.9 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;
- Олон улсын өнгөрөлтийн нислэгийг 41.2 мянга, буулт хөөрөлтийг 29.1 мянгад хүргэх;
- Бүх төрлийн тээврээр 141.0 сая.тн ачаа, 150.0 сая зорчигч тээвэрлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус яам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2025.07.09/
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2025.06.25, 2025.07.09/
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/329 “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” тушаал
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/106 дугаар “Ажлын байрны жагсаалт, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаал

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд дотоод аудитын нэгж нь төлөвлөгөөт 11 байгууллагыг шалгалтад хамруулахаас 8 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж, 1 байгууллагыг хамруулаагүй /Ховд АЗЗА/, 2 байгууллагын /Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Монгол Улсын Далайн захиргаа/ хяналт, шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,925,939.0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	544.4	0.00	-544.4
Авлага	5,229,439.6	3,671,436.9	-1,558,002.7
Урьдчилж төлсөн төлбөр	0.00	1,087.9	1,087.9
Бараа материал	120,318.6	97,421.8	-22,896.8
Үндсэн хөрөнгө	5,500,712.8	5,155,129.8	-345,583.0
Нийт хөрөнгийн дүн	10,851,015.4	8,925,076.4	-1,925,939.0
Өр төлбөр	1,559.2	1,138,741.3	1,137,182.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,849,456.2	7,786,335.1	-3,063,121.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	10,851,015.4	8,925,076.4	-1,925,939.0

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Тайлант онд авлагын данс 1,558,002.7 мянган төгрөгөөр буурсан нь жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын үлдэгдэл санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,155,129.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 345,583.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө бэлтгэсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон, барилгын дээврийг капиталжуулж бүртгэсэн, нийт 464,891.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд

бүртгэж, 1,221,266.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, элэгдлийн зардал 410,791.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн;

- Өглөгийн дансны үлдэгдэл 1,137,182.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгасан хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээлийн хүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжүүлэх төсөвгүйгээс өр төлбөрийг хуримтлуулан бүртгэсэн;
- Цэвэр хөрөнгө/өмчийн дүн 3,063,121.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхэд урсгал зардлыг 16,277,099.5 мянган төгрөгөөр төлөвлөж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн ирүүлсэн төсвийн төслийн саналаас 2,928,181.4 мянган төгрөгөөр бууруулж, 13,348,918.1 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, урсгал санхүүжилтийг батлагдсан төсвөөс 1,221,740.1 мянган төгрөгөөр бууруулан 12,127,178.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 518,271.0 мянган төгрөгөөр, цалин, нийгмийн хамгааллын шимтгэлийг 446,655.7 мянган төгрөгөөр, татаасыг 96,475.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 77,008.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 73 дугаар "Төмөр замын газар байгуулах тухай" тогтоолоор төмөр замын агентлаг байгуулагдаж¹, орон тоог 48-аар баталж, яамны орон тоо 151 байсныг 14-өөр бууруулж, 137 болгож өөрчилсөнтэй холбоотойгоор Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хооронд төсөвт зохицуулалт хийж, урсгал зардлыг 491,113.3 мянган төгрөгөөр бууруулж, 11,636,064.7 мянган төгрөгөөр өөрчлөн баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 10,884,524.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 225,087.8 мянган төгрөгийг улсыг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,659,436.8 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 470,157.8 мянган төгрөгөөр урсгал шилжүүлгийг 285,025.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлжээ.

¹ Засгийн газрын 2025 оны 73 дугаар "Төмөр замын газар байгуулах тухай" тогтоолын 2-т "Төмөр замын газрын орон тооны дээд хязгаарыг 48 байхаар тогтоосугай"

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	7,491,951.7	7,270,508.4	221,443.3	97.0
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	17,850.0	17,850.0	0.0	100.0
3	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	433,114.9	433,114.9	0.0	100.0
4	80404 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,892,990.7	2,422,832.9	470,157.8	83.7
5	80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	31,484.5	0.0	31,484.5	0.0
6	80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	288,604.9	286,400.0	2,204.9	99.2
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	374,837.7	123,501.3	251,336.4	32.9
8	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	105,230.3	105,229.3	1.0	100.0
	Нийт дүн	11,636,064.7	10,659,436.8	976,627.9	91.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/173 дугаар “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” тушаалын 10.3-т “Албан хаагчдын ажлын 1 өдрийн хоолны мөнгө 34.0 мянган төгрөг, унааны мөнгө нь 3.0 мянган төгрөгөөс багагүй байна.” гэж заасны дагуу давхардсан тоогоор 1630 албан хаагчид нийт 1,002,626.7 мянган төгрөгийг олгосон;
- Монгол Улсын ерөнхийлөгчийн Турк улсад хийсэн төрийн айлчлал, Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлал, Бүгд Найрамдах Узбекистан Улсад зохион байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх анхдугаар хуралд оролцох, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад зохион байгуулсан олон улсын хуралд оролцох, Мароккогийн Хаант улсын тээвэр, логистикийн яам болон Нэгдсэн үндэстний байгууллагын Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хамтран зохион байгуулсан арга хэмжээ, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын "Техник, Эдийн засгийн Хамтын ажиллагааны Хөтөлбөр" хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажил гүйцэтгэх гэрээ хэлэлцээр хийх нийт 7 удаагийн гадаад томилолтын зардалд 147,619.9 мянган төгрөгийг санхүүжүүлсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн 4, албан хэрэг хөтлөлтийн 1, нийт 5 программ бүртгэлтэй бөгөөд үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэлийн Юникус, Динамик программ, албан хэрэг хөтлөлтийн Able cloud программыг үйл ажиллагаандаа ашигладаг;
- Албан хаагчдад чиглэсэн 9 удаагийн чадавхжуулах сургалт, хурал зөвлөгөөн түүнтэй адилтгах 2 арга хэмжээнд нийт 85,726.5 мянган төгрөгийг зарцуулсан;

- Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор нэр бүхий 3 байгууллагатай гэрээ байгуулж, 17,850.0 мянган төгрөгийг олгосон;
- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалж ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас нөхөн олговрыг олгоогүй;
- Засгийн газрын 2024 оны 6 дугаар "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" тогтоолоор тус яамны орон тооны хязгаарыг 151 байхаар баталсан бөгөөд Засгийн газрын 2025 оны 73 дугаар "Төмөр замын газар байгуулах тухай" тогтоолоор төмөр замын агентлагийг байгуулж, яамны бүтцэд өөрчлөлт оруулж, орон тооны хязгаарыг 137 байхаар бууруулан баталжээ. Төрийн албаны чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлогын хүрээнд Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" тогтоолоор орон тоог 12-оор бууруулж, 125 болгон өөрчлөн баталсан бөгөөд гүйцэтгэлээр 119² албан хаагч ажиллаж байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын 2025 оны 50, 55, 282 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 2,660,845.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 50,984.4 мянган төгрөг, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 90,640.2 мянган төгрөг, өмнөх оны санхүүжилтээс 5,209,809.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлж, 2,660,845.1 мянган төгрөгийг зориулалт, эрэмбийн дагуу бараа үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж, 1,686,418.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, албан журмын даатгагчдын холбооны хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлэх 3 арга хэмжээний 3,665,015.4 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Зам, тээврийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалын хавсралтаар тус яамны урсгал төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 298,633.5 мянган төгрөгийн 5 бараа, ажил үйлчилгээг зохион байгуулахаар тусгажээ. Үүнд: 188,633.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Засгийн газрын XIII байрны гадна дээвэр, урсгал засварын ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 90,000.0 мянган төгрөгийн 3 барааг ерөнхий гэрээний аргаар, 20,000.0 мянган төгрөгийн техник, хэрэгслийг гэрээ шууд байгуулахаар заажээ.

² 2025 оны 12 дугаар сарын байдлаар

Гүйцэтгэлээр гадна дээвэр, урсгал засварын ажил болон техник хэрэгсэл худалдан авах 2 арга хэмжээ хэрэгжиж, ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах 3 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зам, тээврийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Зам, тээврийн яам түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулах, газрыг үнэлж, бүртгэх, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/385 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар, суурь үзүүлэлтийг нийт зардлын дүнгээс тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 17,150,783.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 171,507.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитын төлөвлөх үе шатанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 29 горим, сорил хэрэгжүүлэхэд хуулиар хязгаарласан зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 13,166,573.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 32,091,962.5 мянган төгрөгийн 336 мэдээ, гүйлгээ байршуулахаас 18,925,388.7 мянган төгрөгийн 231 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 13,166,573.8 мянган төгрөгийн 61 мэдээ, гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 44 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, мөн хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалт, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн данстад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, батлуулах, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулж, бүртгэлд тусгах асуудлуудыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 5,654.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 5,926,480.5 мянган төгрөгийн 11 албан шаардлага, 21,109,590.8 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгснийг үнэлэхэд төлбөрийн акт, албан шаардлагууд бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Акт	2	5,654.1	2	5,654.1	100.0
2	Албан шаардлага	11	5,926,480.5	11	5,926,480.5	100.0
3	Зөвлөмж	8	21,109,590.8	7	19,867,986.2	99.2
	Нийт дүн	12	27,041,725.4	20	25,800,120.8	99.7

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.51 дэх хэсгийн Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих 3 талт Санхүүжилтийн ерөнхий гэрээний хэрэгжилтийг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар УСНББОУС 1-ийн 21, 27, 48-52 дугаар заалт, УСНББОУС 3-ийн 47-52 дугаар заалтад нийцээгүй нийт 657,368.3 мянган төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа: Санхүүгийн байдлын тайланг, техник хяналтын зардлын тайлантай нэгтгэж гаргасныг тусад нь бэлтгүүлэв.

Аудитаар нийт 1,226,415.5 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 4,423.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,145,636.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 76,356.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 1,226,415.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 171,507.8 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа албан хаагчдын цалингийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад нэр бүхий 3 албан хаагчийн албан тушаалын цалингийн нэмэгдлийг буруу тооцоолж, 4,423.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад илүү олгосон цалингийн нэмэгдлийг холбогдох этгээдээр төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.51 дэх хэсэгт Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих 2 жилийн хугацаатай, Засгийн газраас зээлийн нийт хүүгийн 7.0 хувийг хариуцан төлөх, 145,000,000.0 мянган төгрөгийн зээлийг арилжааны банкнуудын эх үүсвэрт тулгуурлан олгохоор баталсан. Дээрх хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 79-193/01/110/0523/72 дугаар 3 талт Санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулжээ.

Тайлант онд тус яам 1,096,397.5 мянган төгрөгийн зээлийн хүүгийн дэмжлэгийн өр төлбөр үүсгэж, харилцагчидтай тооцоо нийлээгүй, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт бүртгэлээр хяналт тавиагүй, Санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан эрх үүргийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг

удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Монголбанкны хамтарсан 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 79-193/01/110/0523/72 дугаар Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгасан "Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 5-д "Засгийн газраас зээлдэгчид олгох зээлийн хүүгийн дэмжлэг", 5.2, 5.7, 6.5.1, 6.6.1, 6.6.2-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдэд олгосон зээлийн төлбөрийн тооцоонд хяналт тавиагүй, гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус яам нь нэр бүхий хуулийн этгээдтэй Засгийн газрын XIII байрны дээвэр болон албан тасалгаанд урсгал засварын ажил гүйцэтгэх 174,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, засварын ажлыг гүйцэтгүүлсэн ба гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгааны барьцаа 5.0 хувь буюу 8,700.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.6-д "чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх", Засгийн газрын XIII байрны дээвэр болон албан тасалгааны урсгал засварын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 6.7-д "Чанарын баталгаа шаардана. Ашиглалтад хүлээлгэж өгснөөс хойш 1 жил байна. Барьцаа хөрөнгийн хувь нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгчид ажлын санхүүжилтийг олгохдоо чанарын баталгааны барьцаа хөрөнгийг суутган тооцож, холбогдох дансанд байршуулдаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд төсвийн захирагч төсвийг зохистой удирдаагүйгээс 40,539.0 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Үүнд: 16 албан хаагчийн 2-10 дугаар сарын хугацаан дахь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 16,330.0 мянган төгрөг, ёс зүйн хорооны урамшуулал 5,148.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж 3,000.0 мянган төгрөг, байр ашиглалтын 16,061.0 мянган төгрөгийн төлбөр тус тус байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх.", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар

зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүй өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 59,384.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд үүнээс төлөвлөх боломжтой тогтмол түрээсийн орлогыг төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах;" , 27 дугаар зүйлийн 27.1.7-д "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах." гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулах.

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайлангийн ХХОАТ-ын авлагын дүн татварын тайлангийн дүнгээс 9,152.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" , 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулж, бүртгэлд тусгаж байх.

3. Газартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд санхүүгийн тайланд үнэлж, тусгаагүй 14 байршилд байрлалтай газрын төлбөрт 7,818.6 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" , 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" , Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч, газрыг үнэлж, бүртгэлд тусгах.

4. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайлангаа холбогдох хууль, тогтоомж, батлагдсан загварын дагуу иж бүрэн бэлтгэж, ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:", 54.5.1-д "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/"; 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл"; 54.5.4-д "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/"; 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, Төрийн аудитын байгууллагад ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн байдлын тайланг, техник хяналтын зардлын тайлантай нэгтгэж бэлтгэснийг тусад тайлагнасан.	1	657,368.3			1	657,368.3	1	657,368.3				
	Дүн	1	657,368.3			1	657,368.3	1	657,368.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Нэр бүхий 3 албан хаагчийн албан тушаалын цалингийн нэмэгдлийг буруу тооцоолж, 4,423.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1	4,423.0	1	4,423.0								
2	Тус яам 1,096,397.5 мянган төгрөгийн зээлийн хүүгийн дэмжлэгийн өр төлбөр үүсгэж, харилцагчидтай тооцоо нийлээгүй, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт бүртгэлээр хяналт тавиагүй, Санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан эрх үүргийн холбогдох эрх зээлийн заалтуудыг хэрэгжүүлээгүй.	1	1,096,397.5			1	1,096,397.5						
3	Тус яам нь нэр бүхий хуулийн этгээдтэй Засгийн газрын XIII байрны дээвэр болон албан тасалгаанд урсгал засварын ажил гүйцэтгэх 174,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, засварын	1	8,700.0			1	8,700.0						

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ажлыг гүйцэтгүүлсэн ба гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгааны барьцаа 5.0 хувь буюу 8,700.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй.											
4	Төсвийн захирагч төсвийг зохистой удирдаагүйгээс 40,539.0 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	40,539.0			1	40,539.0					
5	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 59,384.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд үүнээс төлөвлөх боломжтой тогтмол түрээсийн орлогыг төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй.	1	59,384.5				1	59,384.5				
6	Санхүүгийн байдлын тайлангийн ХХОАТ-ын авлагын дүн татварын тайлангийн дүнгээс 9,152.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	9,152.9				1	9,152.9				
7	Санхүүгийн тайланд бүртгэлгүй 14 байршилд байрлалтай газрын төлбөрт 7,818.6 мянган төгрөгийг төлсөн бөгөөд газрыг үнэлж, бүртгэлд тусгаагүй.	1	7,818.6				1	7,818.6				
8	Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайлангаа холбогдох хууль, тогтоомж, батлагдсан загварын дагуу иж бүрэн бэлтгэж, ирүүлээгүй.	1	0.0				1	0.0				
	Дүн	8	1,226,415.5	1	4,423.0	3	1,145,636.5	4	76,356.0			

Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим мэдээллийн санд нийт 32,091,962.5 мянган төгрөгийн 336 мэдээ, гүйлгээ байршуулахаас 13,166,573.8 мянган төгрөгийн 61 мэдээ, гүйлгээг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 44 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй.	1	13,166,573.8			1	13,166,573.8		
	Нийт дүн	1	13,166,573.8	-	-	1	13,166,573.8		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 17/А0160080

Улаанбаатар хот

САГ-2026/189/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа албан хаагчдын цалингийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад нэр бүхий 3 албан хаагчийн албан тушаалын цалингийн нэмэгдлийг буруу тооцоолж, 4,423,024.00 /Дөрвөн сая дөрвөн зуун хорин гурван мянга хорин дөрвөн/ төгрөгийг илүү олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон цалингийн нэмэгдэл 4,423,024.00 /Дөрвөн сая дөрвөн зуун хорин гурван мянга хорин дөрвөн/ төгрөгийг холбогдох этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, яамны нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Хонгорзул/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, II-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA16987
9796571411

Z:\4h\2026\0225 SAG-11.Docx

1526200053



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119/АД160080

Улаанбаатар хот

САГ - 2026/89/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.51 дэх хэсэгт Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих 2 жилийн хугацаатай, Засгийн газраас зээлийн нийт хүүгийн 7 хувийг хариуцан төлөх, 145,000,000,000.00 төгрөгийн зээлийг арилжааны банкнуудын эх үүсвэрт тулгуурлан олгохоор баталсан. Дээрх хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 79-193/01/110/0523/72 дугаар 3 талт Санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулжээ.


Тайлант онд тус яам 1,096,397,507.79 /Нэг тэрбум ерэн зургаан сая гурван зуун ерэн долоон мянга таван зуун долоон төгрөг далан есөн мөнгө/ төгрөгийн зээлийн хүүгийн дэмжлэгийн өр төлбөр үүсгэж, харилцагчидтай тооцоо нийлээгүй, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт бүртгэлээр хяналт тавиагүй, Санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан эрх үүргийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Монголбанкны хамтарсан 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 79-193/01/110/0523/72 дугаар Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгасан "Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 5-д "Засгийн газраас зээлдэгчид олгох зээлийн хүүгийн дэмжлэг", 5.2-т "Зам, тээврийн хөгжлийн яам Монголбанкнаас ирүүлсэн зээлийн хүүгийн дэмжлэгийн тооцоог нягталж, Санхүүжилтийн эрх нээх мэдэгдлийг Сангийн яаманд ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.", 5.7-д "Зээлийн хүүгийн дэмжлэгийг зээлийн бодит үлдэгдлээс тооцно.", 6.5.1-т "Гэрээний 2.1.9-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд зээлийн хүүгийн дэмжлэгийг цуцлах", 6.6.1-т "Засгийн газраас олгох зээлийн хүүгийн дэмжлэгийг улсын төсвийн төсөлд тусгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлэх", 6.6.2-т "Зээлийн хүүгийн дэмжлэгийн Санхүүжилтийн эрх нээх мэдэгдлийг Сангийн яаманд хүргүүлэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-т “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдэд олгосон зээлийн төлбөрийн тооцоонд хяналт тавиагүй, гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, яамны нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Хонгорзул/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 120/АО160080

Улаанбаатар хот

САГ - 2026/89/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсвийн захирагч төсвийг зохистой удирдаагүйгээс 40,538,958.00 /Дөчин сая таван зуун гучин найман мянга есөн зуун тавин найман/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Үүнд: 16 албан хаагчийн 2-10 дугаар сарын хугацаан дахь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 16,329,988.00 /Арван зургаан сая гурван зуун хорин есөн мянга есөн зуун наян найм/ төгрөг, ёс зүйн хорооны урамшуулал 5,148,000.00 /Таван сая нэг зуун дөчин найман/ төгрөг, нэг удаагийн тэтгэмж 3,000,000.00 /Гурван сая/ төгрөг, байр ашиглалтын 16,060,970.00 /Арван зургаан сая жаран мянга есөн зуун далан/ төгрөгийн төлбөр тус тус байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх.", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;", 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүй өр төлбөр үүсгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, яамны нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Хонгорзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 121/А0160080

Улаанбаатар хот

САГ-2026/89/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яам нь нэр бүхий хуулийн этгээдтэй Засгийн газрын XIII байрны дээвэр болон албан тасалгаанд урсгал засварын ажил гүйцэтгэх 174,000,000.00 /Нэг зуун далан дөрвөн сая/ төгрөгийн гэрээ байгуулж, засварын ажлыг гүйцэтгүүлсэн ба гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгааны барьцаа 5.0 хувь буюу 8,700,000.00 /Найман сая долоон зуун мянган/ төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.13-т "төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх, кодлох, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг батлах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх", 4.2.2.6-д "чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх", Засгийн газрын XIII байрны дээвэр болон албан тасалгааны урсгал засварын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 6.7-д "Чанарын баталгаа шаардана. Ашиглалтад хүлээлгэж өгснөөс хойш 1 жил байна. Барьцаа хөрөнгийн хувь нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэгчид ажлын санхүүжилтийг олгохдоо чанарын баталгааны барьцаа хөрөнгийг суутган тооцож, холбогдох дансанд байршуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, яамны нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Хонгорзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 122/А0160080

Улаанбаатар хот

САГ-2026/89/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд нийт 32,091,962,521.85 /Гучин хоёр тэрбум ерэн нэгэн сая есөн зуун жаран хоёр мянга таван зуун хорин нэгэн төгрөг наян таван мөнгө/ төгрөгийн 336 мэдээ, гүйлгээ байршуулахаас 18,925,388 710.00 /Арван найман тэрбум есөн зуун хорин таван сая гурван зуун наян найман мянга долоон зуун арван/ төгрөгийн 231 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 13,166,573,811.85 /Арван гурван тэрбум нэг зуун жаран зургаан сая таван зуун далан гурван мянга найман зуун арван нэгэн төгрөг наян таван/ төгрөгийн 61 мэдээ, гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 44 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-т "хууль

тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, яамны нягтлан бодох, санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Хонгорзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ